



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 9/34

Өвт

Г Хэсэгчилсэн хязгаарлалтын дэглэмийг
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дэх заалт, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5, 19 дүгээр зүйлийн 19.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 1, 2, 6 дугаар багийн нутаг дэвсгэрт малын гоц халдварт шүлхий өвчиний сэжигтэй тохиолдлууд бүртгэгдэж 1, 2, 6 дугаар багийн нутаг дэвсгэрт хэсэгчилсэн хязгаарлалтын дэглэм тогтоосон хугацаа 2022 оны 03 дугаар сарын 08-нд дууссан ч малын өвчин бүрэн эдгэрээгүй гэсэн Мал эмнэлгийн тасгийн дүгнэлтийг үндэслэн хэсэгчилсэн хязгаарлалтын дэглэмийг 2022 оны 03 дугаар сарын 09-өөс эхлэн 28 хоногоор сунгасугай.

2. Малын гоц халдварт шүлхий өвчин тархахаас хамгаалах, хязгаарлалтын дэглэм сахиулах, малын гоц халдварт шүлхий өвчиний талаарх мэдээллийг малчдад хүргэх, үнэн зөв мэдээллээр хангах, малчдыг малаа байнгын хариулгатай байлгахад хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн нэгж, багийн Засаг дарга наарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

